



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 06 өдөр

Дугаар А/549

Есөнбулаг

Э.Даваадоржид дэмжлэг үзүүлэх  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалт, 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4 дэх заалт, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 35 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бүгд Найрамдах Солонгос Улсад зохион байгуулагдах “2023 FAI World Drone Racing Championship Drone Coding Competition” тэмцээнд оролцох Ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн дизайн, технологийн багш Энхбаярын Даваадоржийн замын зардалд дэмжлэг үзүүлсүгэй.

2.Шаардагдах 1,684,844 (нэг сая зургаан зуун наян дөрвөн мянга найман зуун дөчин дөрөв) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР